

ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД СЭТГҮҮЛЧИЙН АЖЛЫН ЗАРИМ ОНЦЛОГ

Т.Өнөрсайхан*, С.Бат-Оюун**

* МУИС, Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

** Сэтгүүл зүйн магистр (MA)

Түлхүүр үгс: байгалийн гамшиг, жагсаал цуглаан, дайн, сэтгүүлч, онцгой байдал.

Аливаа олон нийт уур бухимдал, баяр баясгалан, айдас түгшүүр гэсэн сэтгэл зүйн гурван хүчин зүйлийн хүрээнд үүсэж бий болдог гэж Сципион Сигеле “Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг” бүтээлдээ дурдсан байдаг. Ингэж сэтгэл хөдлөлийн огцом өөрчлөлтийн туйлд хүрсэн тэдний үйлдлийн үр дагавар нь ихэнхдээ нийгэмд онцгой нөхцөл байдлыг үүсгэдэг байна. Үүнийг сурвалжилж мэдээлэх нь сэтгүүлчийн үйл ажиллагааны нэг хэсэг юм. Гэхдээ өдөр тутмын сурвалжилгатай харьцуулахад эрсдэл өндөртэй, сэтгүүлчээс мэргэшлийн ур чадвар, хувь хүний сэтгэл зүйн болоод бие физиологийн бэлтгэлийг шаарддаг онцлогтой билээ.

Онцгой нөхцөл байдал харьцангуй бага үүсдэг нийгэм цаг үе, улс үндэстний онцлог нь манай сэтгүүл зүйн салбарт нөлөөлжээ. Сургалт, судалгааны салбарт энэ чиглэлийн бие дааж дагнасан судалгаа байхгүй, МУИС-д гэхэд Глобал сэтгүүл зүй хичээлээр хязгаарлагдаж байна. Гэтэл манай улсад 2020 онд том жижиг 237 жагсаал цуглаан болсон бол 2021 оны 11 дүгээр сарын байдлаар 214 жагсаал цуглаан

бүртгэгджээ. Жилийн 365 хоногтой харьцуулахад 70 гаруй хувьд нь жагссан байна. (Сандаг-Очир, 2021)

Судалгааны бусад байгууллагууд, мэргэжлийн холбоодын тухайд сэтгүүлчийн аюулгүй байдлын талаар цөөн тооны гарын авлагад дэд хэсэгт оруулах эсвэл дурдагдах төдий бичжээ. МСНЭ-ээс 2012 онд гаргасан гурван заалт бүхий зөвлөмж, бусад мэргэжлийн холбоодоос онцгой нөхцөл байдалд ёс зүйн зарчмаа баримтлан ажиллахыг уриалсан зөвлөмжүүд, мэргэжлийн ёс зүйн дүрэмд заасан цөөн хэдэн заалтаас өөр гарын авлага болгох бичиг баримт алга байна. Онцгой нөхцөл байдалд ажиллаж буй сэтгүүлч эрсдэлд өртөхөд үзүүлэх сэтгэл зүй, санхүү, эрүүл мэндийн тусламжийн талаар ч тодорхой шийдэлгүй байна. Редакцуудад ч ийм төрлийн сурвалжилга хийж буй сэтгүүлчдэдээ өгөх нэгдсэн зөвлөмж зөвлөгөө дутагдаж байна. Гэтэл Монгол орны нутаг дэвсгэрт 2021 онд 119,800 удаагийн газар хөдлөлт, үүнээс хүнд мэдрэгдэх хэмжээний буюу 3.5 магнитуд болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 259, зургаан магнитудтай газар хөдлөлт хоёр удаа болсон байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон газар хөдлөлтийн дундаж үзүүлэлттэй

харьцуулахад газар хөдлөлтийн нийт тоо 5,7 дахин, хүнд мэдрэгдэм газар хөдлөлтийн тоо зургаа дахин өссөн үзүүлэлттэй байна. (ЗГ, 2021)

Дээрх баримтаас дүгнэхэд онцгой нөхцөл байдал үүсэх янз бүрийн эрсдэлт байдал нэмэгджээ. Тиймээс ийм үед ажиллах сэтгүүлчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, тэдэнд дэмжлэг үзүүлэх зөвлөмж, гарын авлагыг боловсруулж, төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулахаас гадна редакцын эрсдэлийн менежмент, мэргэжлийн байгууллага холбоодын төрөл бүрийн үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатай байна.

Иймд зохиогчид тус өгүүллээрээ онцгой нөхцөл байдал гэж юу болох, ийм үед сэтгүүлчдийн ажиллах онцлог, зөвлөмж, редакц болон мэргэжлийн байгууллагуудаас үзүүлэх тусламж дэмжлэгийн талаар түүхчлэн үзэх, харьцуулан судлах аргуудыг ашиглан нэгтгэн дүгнэж бичсэн болно.

Онцгой нөхцөл байдал гэж олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, байгалийн гамшиг, үймээн самуун, зохион байгуулалттай болон зохион байгуулалтгүйгээр төрөөс гаргасан шийдвэрүүдийг эсэргүүцэж үзэл бодлоо илэрхийлэхийн төлөө нэгдсэн олон нийтийн жагсаал цуглааныг хэлнэ. Мөн улс эх оронд болж буй байгалийн гамшиг, дотоодын үймээн самуун, хүн бүр өөрийн үзэл бодол, санал шүүмжийг бусдын эрхийг зөрчилгүйгээр илэрхийлэх эрх, эрх чөлөөг зөрчсөн, хэм хэмжээнээс хэтэрсэн янз бүрийн хэлбэрийн эмх замбараагүй байдлыг багтааж ойлгодог байна. (Арапова, 2012) Өөрөөр хэлбэл, нийгмийн хэвийн амьдралын хэмнэлийг эвдсэн ямар ч үйл явдлыг онцгой нөхцөлд тооцдог. Дайн байлдаан бол

онцгой нөхцөл байдлын хамгийн хүнд хэлбэр юм.

Онцгой нөхцөл байдлыг байгалийн болон гаднын оролцоотой хүчин зүйл гэсэн ерөнхий хоёр ангиллаар авч үздэг. Байгалийн хүчин зүйлд газар хөдлөлт, газрын гулгалт, хуй салхи, хүчтэй бороо, цунами зэрэг багтдаг бол гаднын оролцоотой хүчин зүйлд техникийн осол, нийгмийн чанартай үймээн самуун, дайн бослого, жагсаал цуглаан хамаарна. Энэ үед ажиллах сэтгүүлчдийн үйл ажиллагааны онцлог нь ердийн үеийнхээс эрс ялгаатай байдаг.

Тухайлбал, *онц байдал*. Корона вирусийн цар тахлын үед хөл хорио тогтоож, онц байдлын өмнөх зэрэглэлд олон орон шилжсэн билээ. Энэ үед сэтгүүлчдэд тохиолдсон нийтлэг бэрхшээл нь мэдээ мэдээллээ хараат бус байдлаар бэлдэх байсан юм. Хөл хорио тогтоох, онц байдал зарласан үед сэтгүүлч өөрийн эрх үүргийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулж чадахаа больдог. Ихэнхдээ сэтгүүлчид засгийн газар болон хүчний байгууллагаас өгч буй дүрэм журам, зааварчилгааны дагуу ажиллах нөхцөл үүсдэг байна. Уг нь ийм үед сэтгүүлчид эрх баригчдын хүссэн мэдээллийг дамжуулагч бус харин “хоточ нохой”-н үүргийг хамгийн сайн биелүүлэх ёстой байдаг. Ингэснээр иргэд болж буй үйл явдлын тухай тодорхой мэдээлэл авахын зэрэгцээ цаашид онц байдал зарлагдах эсэх, зарлагдсан тохиолдолд үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх янз бүрийн арга хэмжээ авах боломжтой болдог юм.

Терроризм. Урьдчилан төлөвлөж, олон хүний амь насыг тодорхой зорилгоор хөнөөх зохион байгуулалттай гэмт хэрэг юм. Терроризмын мэдээллийг хүргэхдээ үндсэн хоёр зарчимд тулгуурладаг. 1. Дамжуулсан

мэдээлэл нь цаг үеэ олсон, үнэн бодит байх, 2.Мэдээллийг тэнцвэртэй хүргэх буюу хүмүүс барьцаалагдсан тохиолдолд халдлага үйлдэгчдийг зөвтгөсөн эсвэл дэвэргэсэн мэдээлэл хүргэж болохгүй.

Жагсаал цуглаан, эмх замбараагүй байдал. Ийм нөхцөл байдал үүссэн үед асуудлыг гурван талаас нь авч үзэх нь зүйтэй юм. Хүмүүсийн хувьд айдас түгшүүр, сэтгэл зүйн цочролд орж ямар ч мэдээлэлд итгэх итгэл нь нэмэгддэг байна. ОНМХ-ийн хувьд тэнцвэрт, бодит мэдээлэл хүргэснээр хүлээн авагчдын итгэл үнэмшлийг олох боломж нэмэгддэг. Харин жагсаалд оролцогчид, зохион байгуулагчид телевизээр өөрийн үзэл бодлыг ухуулан сурталчлах, хэвлэл мэдээллийн оролцоотойгоор нэр хүндээ өргөх гэсэн ашиг сонирхлын нийтлэг хандлагатай байдаг.

Онцгой нөхцөл байдал үүссэн бүсэд ажиллах сэтгүүлчдийг тодорхой чиглэлээр мэргэшүүлэх нь учирч болзошгүй эрсдэлийг бууруулах үндсэн ажил юм. Ойн түймэр дэгдэж буй газар ажиллах сэтгүүлчдийг улиралд тутамд шинээр сургаж байснаас мэргэшсэн сэтгүүлчдийг хол зайтай давтан сургалтад хамруулах нь илүү үр өгөөжтэй. Нөгөө талаар тухайн сэтгүүлч өөрийгөө эрсдэлээс хамгаалах мэдлэг чадвар тодорхой түвшинд нэгэнт эзэмшсэн байдаг билээ.

Тиймээс манайд ийм төрлийн зөвлөмжийг бий болгох, үйл ажиллагааны чиглэлүүдийг хөгжүүлэхэд нэмэр болох зорилгоор тус өгүүлэлд Англи, АНУ, ОХУ-ын мэргэшсэн сэтгүүлчдийн баримталдаг баримт бичиг зөвлөмжүүдийг харьцуулан авч үзлээ.

Онцгой нөхцөл байдалд ажиллах сэтгүүлчийн үйл ажиллагааг томилолтоос өмнө, томилолтын үед, томилол-

тын дараа гэж гурван хэсэгт хуваана. Нийтлэг энэ байдлыг улам боловсронгуй болгож ВВС өөрийн онцлог бүхий зааврыг боловсруулсан байна. ВВС телевизийн сэтгүүлчид замд гарахын өмнө, томилолтын үед, томилолтын дараа гэсэн гурван ерөнхий хэсгээр үйл ажиллагаагаа зохицуулдаг. (ЮНЕСКО, ХХС, 2002)

1.Замд гарахын өмнө:

- Аюултай газар орчныг тодорхойлох- үүнд ажилтнуудын аюулгүй байдалд онцгой буюу хэвийн бус өндөр эрсдэлүүдийг учруулж болох аливаа газрын жагсаалтыг сар бүр шинэчлэн гаргадаг байна. Ингэхдээ онцгой өндөр эрсдэлтэй буюу дайн тулааны нөхцөл зонхилсон газар, хэвийн бус өндөр эрсдэлтэй буюу иргэний үймээн самуун ихтэй, бослого хөдөлгөөн зонхилсон газар гэж ангилж жагсаалтыг бүлэглэжээ.

- Даалгавар удирдагчийн хариуцлагын хүрээнд сурвалжлах үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх байгууллага, хүмүүсийн тодорхой мэдээлэл, учирч болзошгүй эрсдэл, хамгаалалтын багаж хэрэгслээр хангагдсан байдал, урьдчилсан сургалтад хамрагдсан эсэхийг бататгасан баримт бичгүүдийг бөглөдөг байна.

- Сэтгүүлчид болон бусад ажилтнуудын урьдчилсан сургалтаар ямар төрлийн онцгой нөхцөл байдал бүхий газар очиж байгаагаас хамааран шаардлагатай чадваруудыг эзэмшүүлэхийг зорьдог байна. Тухайлбал, эхний ангилал буюу дайн тулаантай бүс нутагт явж байгаа тохиолдолд а). Дэлхийн олон газар оронд тулгарч байсан янз бүрийн эрсдэлт байдлын талаарх дайсагнасан орчны сургалт, б). Анхны тусламжийн сургалт, в). Хээрийн замд жолоо барих сургалтад заавал хамруулдаг байна. Хэрвээ халдварт

өвчин тархсан газар ажиллах бол тухайн халдварын талаар болон бус нутгийн онцлогийн талаарх сургалт, халдвараас сэргийлэх сургалт, халдвар авсан тохиолдолд авах арга хэмжээг багтаасан эмнэл зүйн сургалтад хамруулдаг байна.

2. Томилолтын үед:

-Ажиллагааны бэлтгэл

-Ажиллагааны талбар дээр – хамгаалалт, харилцаа холбооны хэрэгслээр хангах

3. Томилолтын дараа:

-Товч тайлан бичих

-Тухайн асуудлын талаарх архивыг шинэчлэх

- Аюулгүйн дүрмийн алдаатай байдлын талаар санал бодлоо илэрхийлэх

-Сэтгэл зүйн дарамт, цочролд орсон бол мэргэжлийн тусламж авах (ЮНЕСКО, ХХС, 2002) гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

ВВС-ийн энэ хувилбарыг олон хэвлэл мэдээллийн байгууллага онцгой нөхцөл байдалд ажиллахад сэтгүүлчдэд хамгийн ойр дөт, ойлгомжтой болсон практик зөвлөмж, удирдамж гэж үздэг. Тиймээс өөрсдийн үйл ажиллагаанд шууд авч ашигладаг байна.

Онцгой нөхцөл байдалд ажиллаж буй сэтгүүлчдийг ёс зүйгээ мөрдөхөөс гадна ийм үед баримтлах мэргэжлийн үйл ажиллагааны онцлогийг харгалзахыг зөвлөдөг. Дэлхий нийтийн нийтлэг дагаж мөрддөг жишиг чиг баримжааг тоймлон авч үзлээ.

-Тэнцвэргүй мэдээлэл үйл явдлын цаашдын хандлагыг өөрчилнө. Тиймээс мэдээллийн эх сурвалжуудын тэнцвэрт байдлыг ямагт хангах. Нэг талд хүлээн авагч буюу нийгэм, нөгөө талд үйл явдлын хохирогчид буюу хохирогчийн ар гэрийнхэн гуравдагч тал буюу аливаа жагсаал цуглаан, үймээн самууныг гардан зохион байгуулагчид

зэрэг олон өнцөгт үйл явдлын субъектүүдийн хоорондох уялдаа холбоо, зангилаа тайллыг сэтгүүлч олон нийтэд ил болгон хүргэх.

-Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, жагсаал цуглааны үед хэвлэл мэдээллийн байгууллагууд үйл явдалд оролцож сурвалжилснаар нөхцөл байдлыг улам дэврээж даамжруулдаг. Хэрэв сэтгүүлч сэтгүүлч тухайн үйл явдалд оролцсоноор хэрэг явдал улам даамжрах шинж ажиглагдвал техник хэрэгслүүдээ нуун далдлах, өөрийгөө сэтгүүлч гэдгийг мэдүүлэхгүй байх шаардлага зарим тохиолдолд үүснэ.

-Тухайн хэргийн хурцадмал байдлын түвшин, хохирлын хэмжээ, жагсаалд оролцож буй иргэдийн тоо, сэтгэл зүйн байр байдлыг тодорхойлох.

-Эмх замбараагүй байдлыг үймээн самуун гэж тайлбарлах нь утга зүйн хувьд зөрчилдөх тул бодит байдлын дүн шинжилгээг хийх

-Үймэлдэн бужигнасан олон нийт тухайн цагт бодит мэдээллийг сэтгүүлчид өгөх боломж хомс байна. Хөөрсөн түмнийг дагасан сэтгэлийн тогтворгүй байдал нь болж буй үйл явдалд бодит дүгнэлт хийх рациональ шинжээ алдсан байдаг.

Жагсаал цуглаан, эмх замбараагүй байдлын үед олон нийт сайтар нягтлаагүй янз бүрийн цуу яриаг түгээгч болдог. Энэ тохиолдолд баталгаагүй мэдээллийг нягтлах нь сэтгүүлчийн үүрэг.

-Зайлшгүй шаардлагагүй бол үймээн самуун болж буй газрын байршил эсвэл гол үйл явдлын халуун цэгийг сурвалжилгадаа дурдахгүй байх. Нөхцөл байдлыг дэвэргэхгүй байх зорилготой.

-Сэтгүүлч өөрийн сэтгэл хөдлөлөө хянах. Нийгмийг сэтгэл зүйн цоч-

ролд оруулж буй аливаа гамшигт үйл явдлыг сэтгүүлч сурвалжилдаг. Энэ тохиолдолд сэтгүүлч хүний хувьд аливаа зүйлээс цочирсон ч үг хэл, нүүрний хувирал, дуу хоолойгоороо сэтгэл хөдлөлөө илэрхийлэхгүй байх.

-Үгийн сонголт, хэл яриагаа сайн хянах. Хөөрсөн түмнийг дагаж сэтгэл хөдлөлд автсан сэтгүүлчийн өдөөн хатгасан, турхирсан, аль нэг талын байр суурийг илэрхий өмгөөлсөн хандлага бүхий үг хэллэгээс үүдэн байдал таагүй тал руугаа даамжирч болзошгүй.

-Мэдээллийн бодит баримтыг гол зорилгоо болгох.

-Оролцогч талуудын нэр, ажил албан тушаал зэрэг тодорхой баримтуудыг хамгийн түрүүнд цуглуулж, мэдээлэлдээ ашиглах

-Жагсагчдын зүгээс хүргүүлсэн шаардах хуудас, өргөх бичгүүдийг өөр найдвартай, баттай эх сурвалжуудаас олж авах.

-Сэтгүүлч аливаа үймээн самууны үеэр гарсан цуст тулалдаан болон бэртэл гэмтлийг шууд эфирээр дамжуулахдаа дэлгэцийн ёс зүйг баримтлах

-Мэдээ бэлтгэн хүргэхэд шаардлагатай багаж төхөөрөмж, шууд эфирийн техник хэрэгслийг ямарваа нэгэн онцлох тэмдэглэгээгүй машинд хийж үйл явдал өрнөж буй газарт очих

-Мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай хэрэгслүүдийг аль болох мэдэгдэхээргүй цомхон байдалтай авч явах.

-Сурвалжилга бэлтгэхдээ зайлшгүй стэнд-ап хийх,

-Ямар ч нөхцөл байдал үүссэн тайван байдлаа хадгалах. Сэтгүүлчийг хэл амаар доромжлох, халдсан тохиолдолд биеэ барьж үүргээ ухамсарлах нь хамгийн зөв шийдэл.

-Жагсаалд оролцогчдын дотор өөрийгөө “манлайлагч, толгойлогч” гэж нэрлэсэн хэн нэгнээс аль болох ярилцлага авахгүй байх.

-Үйл явдлыг байгаа чигээр нь олон нийтэд үзүүлэх,

-Сэтгүүлч онц байдал зарлагдсан үед төрийн эрх баригчдын өмнө хариуцлага хүлээх үүрэггүй. Үндсэн хуулийн дагуу аливаа үйлдлийнхээ хариуцлагыг ард түмэн болоод мэргэжил нэгтнүүдийнхээ өмнө хүлээнэ.

-Онц байдлын үеэр сэтгүүлч албан ёсны мэдээлэл хүргэж байхдаа өөрийн санаа бодлыг илэрхийлж болохгүй.

-Сэтгүүлч аливаа үймээн самууныг сурвалжилж байх үедээ зэвсэг барьж болохгүй.

Энэ бол сэтгүүлчдийн мөрдөх заавар зөвлөмжүүдийг нэгтгэсэн жагсаалт юм. Дээр дурдсанчлан онцгой нөхцөлд байдлыг сурвалжлахад ганц сэтгүүлчийн оролцооноос гадна сурвалжлах үйл ажиллагааг зохион байгуулах редакц, мэргэжлийн тусалцаа үзүүлэх салбарын холбоодын үйл ажиллагаа чухал үүрэгтэй билээ.

-Онцгой нөхцөл байдал тохиолдоход бэлтгэлтэй байх, урьдчилсан олон төрлийн мэргэшлийн сургалтуудыг зохион байгуулах.

-Сургалтыг зөвхөн сэтгүүлчийн үйл ажиллагааны заавар зөвлөмж хэлбэрээр бус тухайн нөхцөл байдалд хэрхэн дасан зохицох, шийдвэр гаргах, шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх байдлаар зохион байгуулах. Тухайлбал, сэтгүүлч барьцаалагдсан тохиолдолд ямар арга хэмжээ авах, стресс бүхий нөхцөл байдалд байгаа бүс нутагт ажиллахдаа харилцаа хандлага нь ямар байх, биеэ хэрхэн авч явах, шаардлагатай тохиолдолд зэвсэг хэр-

хэн ашиглах, биеэ яаж хамгаалах зэрэг сургалтууд болно.

-Сэтгүүлчдийг шаардлагатай хувцас хэрэглэлээр хангах. Тухайлбал, CNN-ийн мэдээллийн албаны сурвалжилгын багийн машинд онцгой үед хэрэглэх хамгаалалтын хувцас, хэрэгсэл бэлэн байдаг байна.

-Эрүүл мэндийн эрсдэл бүхий нөхцөл байдал үүссэн тохиолдолд редакцын зүгээс хүлээх хариуцлага, эрсдэлийн менежмент тодорхой байх.

-Цочирдом үйл явдлыг харсан болон урт хугацааны турш стресс бүхий орчинд байсан сэтгүүлчид сэтгэл зүйн тогтворгүй байдалд ордог. Энэ тохиолдолд редакцын зүгээс эсвэл мэргэжлийн байгууллагын зүгээс туслалцаа үзүүлэх. Тухайлбал, Dart center-ийн үйл ажиллагааны чиглэл нь сэтгүүлчдийн сэтгэл зүйн чиглэлээр хийх сурвалжилгуудыг сайжруулахаас гадна цочролд орсон сэтгүүлчдэд мөн сэтгэл зүйн тусламж үзүүлэх зорилготой юм.

Онцгой нөхцөл байдал гэнэтийн, урьдчилан төлөвлөгдөөгүй байдаг. Хэзээ ч үүсэж болзошгүй нөхцөл байдалд бэлэн байх, ард иргэдийг эрсдэл гамшгаас хамгаалах нь бүх нийтийн үйл хэрэг билээ. Сэтгүүлчдийн оролцоо иргэдийг мэдээллээр хангах төдийгөөр хязгаарлагдаж байгаа мэт боловч мэдээлэлтэй иргэн дараагийн эрсдэлээс өөрийгөө хамгаалж, учирч болзошгүй хохирлоос сэргийлж чаддаг. Ийм үр дүнд хүрэхийн тулд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн салбарынхан онцгой нөхцөл байдалд ажиллах олон талт мэргэшлийн ур чадварыг эзэмших шаардлагатай байна. Үйл явдал, үзэгдэл нь давтагдсаар байгаа ч сурвалжлан мэдээлэх сэтгүүлчдэд дэмжлэг болох төрөл бүрийн баримт бичиг, гарын авлага, практик зөвлөмж байхгүй байгаа нь манай сэтгүүл зүйн

салбарын дутагдалтай тал мөн билээ. Цаашдын үр дүн болоод үр дагавар нь өргөн хүрээнд нөлөөлөх энэ байдлыг засаж залруулахад сургалт, судалгааны салбар, редакцууд, мэргэжлийн байгууллага холбоод хамтран ажиллах хэрэгцээ шаардлага нэгэнт бий болоод байна.

Эшлэл

1. Сандаг-Очир Ц. 2021. УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны хуралдаанд. УБ.
2. Засгийн газар. 2021. Гамшгаас урьдчилан сэргийлэх болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах ажлын хэсгийн хуралдаан. УБ.
3. Арапова Г.Ю. 2012. Освещение журналистами экстремальных ситуаций. Воронеж., стр 139.
4. ЮНЕСКО., ХХС. 2002. Сэтгүүлчдэд туслах зөвлөмж. УБ., х 38.
5. ЮНЕСКО., ХХС. 2002. Сэтгүүлчдэд туслах зөвлөмж. УБ., х 42.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Засгийн газар. 2021. Гамшгаас урьдчилан сэргийлэх болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах ажлын хэсгийн хуралдаан. УБ.
2. Сандаг-Очир Ц. 2021. УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны хуралдаанд. УБ.
3. ЮНЕСКО., ХХС. 2002. Сэтгүүлчдэд туслах зөвлөмж.
4. Сигеле С. 2002. Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг. УБ.
5. Арапова Г.Ю. 2012. Освещение журналистами экстремальных ситуаций.
6. Волкер А. 2009. Сэтгүүл зүйн өөрчлөгдөж байгаа чиг хандлага ба ирээдүй. УБ.
7. Besse B., Desormeaux D. 2007. Television news reporting from design to delivery. P.
8. Commissioner for Human Rights. 2011. Protection of journalists from violence. Str.
9. www.dartcenter.org

Summary

This article discusses the coverage by journalists in extreme situations and protection

of journalists from violence. The author explained the safety guide for journalists who works in extreme situations.